



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/70

Ховд

Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн тавдугаар хуралдааны 5/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх аймгийн их засварын хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 3.13 дахь заалт Сургалтын тоног төхөөрөмж /ШШГГазар-457 анги/ 17.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулах, гэрээ байгуулах, тайлагнах эрхийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар - 457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн захирагч / хурандаа Б.Эрдэнэбат/-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг үндэслэлтэй боловсруулж 02 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр, худалдан авах ажиллагааг 03 дугаар сарын 02-ны дотор холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлттэй, шуурхай зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулж, ашиглалтад хүлээн авах зэрэг хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, үр дүнг 06 дугаар сарын 30-ны дотор тайлагнахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар - 457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн захирагч / хурандаа Б.Эрдэнэбат/-д даалгасугай.

3. Эрх шилжүүлж буй хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын

газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д хариуцуулсугай.

4. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Батсүх/, өмч бүртгэлд тусгахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/, холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж, санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ДҮГЭРЖАВ

